МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАЖ ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ТАНИЛЦУУЛГА

БОАЖЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Ч.Пунцагсүрэн

Улаанбаатар хот
2017 он

УСНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1. Усны талаарх бодлогын баримт бичиг:

“Ус” үндэсний хөтөлбөр (УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоол)

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол),

Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоол),

Ногоон хөгжлийн бодлого (УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол),

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол),

Монгол Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө (Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоол).

УСНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2. Усны салбарын хууль тогтоомжууд:

- **Монгол Улсын Үндсэн хууль** (1992),
- **Усны тухай хууль** (2012 онд шинэчлэн найруулж баталсан),
- Байгаль орчныг хамгаалах тухай (1995),
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай (2011),
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай (2012 онд шинэчлэн найруулж баталсан),
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай (2012 онд шинээр баталсан),
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай (2009),
- **Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай** (1997), **Сэргээгдэх эрчим хүчний тухай** (2007), **Усан замын тээврийн тухай** (2003), **Хүнсний тухай** (2012 онд шинэчлэн найруулж баталсан), **Газрын тухай** (2002 онд баталж, 15 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан), **Тариалангийн тухай** (1995) зэрэг усны асуудалтай холбогдох хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудыг батлаж мөрдөн ажиллаж байна.

УСНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3. Устай холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээр:

Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци /РАМСАР/

(1998.06.05-ны өдөр УИХ-аас Рамсарын конвенцид нэгдэн орох тухай хууль батлан гаргасан),

“Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай”

Засгийн газар хоорондын хэлэлцээр



(1995.02.11)





(1994.04.29)

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Монгол Улсын усны талаар баримталж буй бодлого нь байгалийн зүй тогтолцоонд үндэслэн усны нөөцийг **сав газраар нь** хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд оршиж байна. Үүнийг Усны тухай хуулийн зорилт болгосон.



- Дэлхий дахинд усны менежментийг байгалийн зүй тогтолцоонд үндэслэн усны **сав газраар** хийдэг жишиг тогтсон. Дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжсөн орнууд сав газрын эхэн, дунд хэсэгт амьдарч буй хүмүүс сав газрын адаг хэсэгт амьдарч буй хүмүүсийг хохироож болохгүй, усны нөөцийг ашиглагч нь хамгаалж, ашигласан, бохирдуулсан хэмжээгээр төлөх зарчим баримтлан, экосистемийн үйлчилгээг нэвтрүүлэх, тогтвортой хөгжлийн замаар замнаж байна. **Орон нутагт усны 21 сав газрын захиргаа ажилллаж байна.**

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Засгийн газрын тогтоол:

1. Хуулийн 4.10: Энэ хуулийн 10.1.2-т заасан **сав газар нь сав газрын захиргаатай байх** бөгөөд сав газрын захиргааг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна (“Сав газрын захиргааны талаар авах арга хэмжээний тухай” ЗГ-ын 2012.07.25, №254)
2. Хуулийн 9.1.1: **Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө**г батлах (“Төлөвлөгөө батлах тухай” ЗГ-ын 2013.11.30, №389);
3. Хуулийн 9.1.3: **Усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ**г батлах (2011.10.26, №302, шинэчлэн баталсан. Уг тогтоолын 2-р хавсралт (Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр)-д 2013.09.21, №327, өөрчлөлт оруулсан);

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Засгийн газрын тогтоол:

4. Хуулийн 9.1.5: Усны асуудлаарх салбар дундын зохицуулалт хийх, нэгдсэн удирдлагаар хангах, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах үүрэг бүхий **үндэсний хороо** ажиллуулах (“Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” 2017.01.25, №27, Усны үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсэн).
5. Хуулийн 28.13: Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон усны нөөцийг ашиглах тохиолдолд усны эрэл, хайгуул, судалгааны **зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлнэ** (журам ЗГ-ын 2014.01.18, №12 тогтоолоор батлагдсан).

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

1. Хуулийн 4.6: Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн **усны нөөцийн зөвлөл** (Усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг усны нөөцийн зөвлөл батална)-ийг байгуулж, дүрэм, бүрэлдэхүүнийг батална (БОАЖС-ын 2017.08.18, №А/228, зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан).
2. Хуулийн 4.8: **Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө**г байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална (Өнөөгийн байдлаар усны 29 сав газраас **18 сав газрын** УННМТ-г батлаад байна).

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

3. Хуулийн 10.1.2: Монгол Улсын гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарилалт байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн сав газрыг байгуулж, сав газрын захиргааны бүтэц, зохион байгуулалтыг батлах (“Монгол орны Усны сав газрыг байгуулах тухай” БОАЖС-ын 2009.11.10, №332, усны 29 сав газрыг байгуулсан. “Сав газрын захиргаадын байршлыг тогтоох тухай” БОНХАЖС-ын 2015.02.26, №А-109, **СГ-ын 29 захиргаа →26**, “Сав газрын зарим захиргаадыг татан буулгаж, нэгтгэн зохион байгуулах, байршлыг тогтоох, бүтэц, орон тоо, дүрмийг батлах тухай” БОНХАЖС-ын 2016.03.24, №А/83, **СГ-ын 26 захиргаа →21**);

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

4. Хуулийн 7.2: Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална (“Журам батлах тухай” БОНХС-ын 2014.03.17, №А-86).
5. Хуулийн 10.1.3: усны нөөцийг тооцоолох (“Аргачилсан заавар батлах тухай” БОНХАЖС-ын 2015.04.20, №А-173, “Газрын доорх усны ашиглаж болох боломжит нөөцийг судалж тогтоох, баталгаажуулах аргачилсан заавар”, “Газрын доорх усны хайгуулын үр дүнгийн тайлангийн агуулга бүтцийн загвар”, “Хайгуул-судалгааны ажлын техникийн даалгавар”-ын загвар), усны тоо бүртгэл явуулах (“Журам батлах тухай” БОС-ын 2006.08.22, №269, *шинэчлэж байгаа*)

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

5. Хуулийн 10.1.3: ... усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох (“Усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг батлах” тухай ЗГ-ын 2011.10.26, №302 тогтоолоор баталсан), усны хяналт-шинжилгээ хийх (“Газрын доорх усны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг батлах тухай” БОНХАЖС-ын 2016.07.07, №А/217, “Усны хяналт-шинжилгээ хийх журам” БОНХАЖС-ын 2016.07.07, №А/218), усны сан бүхий газрыг нөхөн сэргээх (“Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”, “Гэрээний загвар” ЗГ-ын 2015.03.30, №120)

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

5. Хуулийн 10.1.3: ... уст цэг, усны барилга байгууламжийг ашиглах, эзэмших (*журмыг ХХААХҮЯ-тай хамтран боловсруулж байна*), ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах (“Журам батлах тухай” БОНХС-ын 2013.05.16, №А-156)-тай холбогдсон журам, зааврыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлах.
6. Хуулийн 10.1.4: Сав газрын менежментийн төлөвлөгөөний аргачилсан зааврыг боловсруулж батлах (“Аргачилсан заавар батлах тухай” БОНХС-ын 2013.06.19, №А-187)

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

7. Хуулийн 10.1.6: Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлал батлах (“Аргачлал батлах тухай” БОНХАЖС-ын 2015.11.18, №А-388),
8. Хуулийн 10.1.12: Ус бохирдуулах аюултай бодисын жагсаалтыг батлах (“Жагсаалт батлах тухай” БОНХАЖС-ын 2015.07.29, №А-294),
9. Хуулийн 20.3: Сав газрын зөвлөлийг байгуулах, ажиллах нийтлэг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална (БОНХАЖС-ын 2013.04.22, №А-124),
10. Хуулийн 21.3: Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална (БОНХС-ын 2013.10.23, №А-307),

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

11. Хуулийн 23.3: Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн талаарх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно (“Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам” БОНХАЖС-ын 2013.03.01, №А/66),
12. Хуулийн 28.17: Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална (БОНХС-ын 2013.05.16, №А-157, “Ус ашиглах гэрээний загвар батлах тухай” БОНХС-ын 2013.12.20, №А-367, “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай” БОНХАЖС-ын 2016.02.05, №А/33).

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын тушаал:

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм (БОНХАЖС-ын 2015.07.30, А/301)

Нормыг баталсан боловч Усны тухай хуульд тусгагдаагүй гэсэн шалтгаанаар ХЗДХЯ бүртгэхгүй байгаа.

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

БОАЖ-ын сайдын болон бусад холбогдох салбарын сайдтай хамтарсан тушаал:

13. Хуулийн 22.4: Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд энэ журмаар онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, бүсэд мөрдөх дэглэмийг тогтооно (“Журам батлах тухай” БОНХАЖС, БХБС-ын хамтарсан 2015.06.05, №А-230/127),
14. Хуулийн 10.1.10: Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлах (*Журмыг шинэчлэн боловсруулж байгаа*)

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА